



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/107

Алтрага

Хүлээж авах хяналт тавих
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн "Эмт багийн зам засвар"-ын ажлыг хүлээж авах, хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Хишигбаяр
(Нягтлан бодогч)
Гишүүн: Г.Бямбажаргал
(ХАА-н тасгийн мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга: Э.Эрдэнэбилэг
(Эмт 1 дүгээр багийн Засаг дарга)

2. 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн "Эмт багийн зам засвар"-ын ажлыг хууль журмын хүрээнд хүлээж авахыг Ажлын хэсгийн ахлагч (Ц.Хишигбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА  ГОДСЭР